

**Санхүү, эдийн засгийн яам
НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр**

Баримтын хуудас

**“ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ
ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ” МОН01/Ю01/99/01 ТӨСӨЛ**

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАР ДАХЬ
ХАНДИВЛАГЧДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН
ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН ЖЕНДЭРИЙН ДҮН
ШИНЖИЛГЭЭ**

Улаанбаатар, 2004

Монгол улсын Засгийн газрын “Эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг”-ийг хэрэгжүүлэх, дунд хугацааны зорилтыг хангах, ядуурлыг бууруулах бодитой ахиц гаргах, жендэрийн тэгш байдлыг хангахад хандивлагч орон, олон улсын байгууллагуудаас олгож байгаа зээл, тусламжийн эцсийн үр дүнг дээшлүүлэх арга замыг судлан тодорхойлох шаардлага тавигдаж байна.

Монгол Улсын Засгийн газар Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1981 он), Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц (1965 он), Эхчүүдийг хамгаалах тухай конвенц, Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш шан хөлс олгох тухай конвенцийг (1981 он) оролцуулан хүний эрхийн 31 гэрээ, конвенцид нэгдэн оржээ.

Монгол Улс 1994 онд Кайр хотноо болсон хүн ам ба хөгжил бага хурал, 1995 онд Бээжинд чуулсан Дэлхийн эмэгтэйчүүдийн бага хурал, мөн онд болсон Копенгагены дэлхийн дээд хэмжээний хурал зэрэг олон улсын томоохон уулзалтуудад амжилттай оролцож, тэдгээрээс гаргасан гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн гарын үсэг зуржээ. Мөн Хөдөөгийн эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах, 1992 оны Женевийн тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн байна.

Жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаарх Монгол улсын төрийн бодлогын үндэс нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй” гэсэн заалт, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль, эрхзүйн бусад баримт бичгүүдээр баталгаажин хэрэгжиж байна.

Эрүүл мэндийн тухай хууль (35, 36 дугаар зүйл), Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль (3 дугаар зүйл), Нийгмийн халамжийн тухай хууль (12, 15 дугаар зүйл), Боловсролын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Иргэний хууль (16, 17, 98 дугаар зүйл), Хөдөлмөрийн тухай хууль (7 дугаар зүйл), Төрийн бус байгууллагын тухай хууль зэрэгт жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн заалтууд тусгагдан хэрэгжиж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-д гэр бүлийн хөгжил, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эхийн жигд оролцоог хангах; гэр бүлийн харилцаанд жендэрийн болон гэр бүлийн гишүүдийн тэгш эрхийг хангаж бие даасан байдлыг хүндэтгэх; жендэрийн чиглэлээр судалгааг цогц байдлаар явуулж, үр дүнг төрийн бодлогод тусган хэрэгжүүлэх талаар тодорхой заасан байна. Мөн энэхүү бодлогын “Гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга зам” гэсэн дөрөвдүгээр

бүлгийн 3-т: “Гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангана” гэж заагаад хэрэгжүүлэх дөрвөн чиглэлийг тусгажээ.

Аймаг, нийслэлийн түвшинд хүн ам, гэр бүлийн асуудал хариуцсан хэлтэс, сум, дүүрэг, хороонд гэр бүлд туслах нийгмийн ажилтан ажиллуулах; мөн салбарын яамдын эрхлэх асуудалтай холбоотой бодлогыг тухайн яам хариуцахаар төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийн мэдээ, тайланг хүн ам зүйн бодлого эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлэх; гэр бүлийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгахаар заасан нь энэхүү бодлогыг ойрын 10-15 жилд бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна.

Монгол Улсын Засгийн газраас 1996 онд “Эмэгтэйчүүдийн байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлээд 2002 онд “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаагаас үзэхэд төр, засгийн бодлогын түвшинд жендэрийн асуудлыг анхаарч байна гэдэг дүгнэлт хийж болох юм.

Үнэ төрийн зохицуулалтгүй болж, хувьчлал явуулж, банкны салбарын шинэтгэл хийж, инфляцийг багасгах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлснээр өнөөгийн байдлаар эдийн засаг өсөх хандлагатай болж байна.

Хүснэгт 1

Эдийн засгийн гол үзүүлэлтүүд

	1990	1992	1995	1997	1999	2000	2001	2002	2003*
Эдийн засгийн өсөлт, хувиар	-2.5	-9.5	6.3	4.0	3.2	1.1	1.0	3.9	5.3
Инфляци, хувиар		325.5	53.1	20.5	10.0	8.1	8.0	1.6	5.0
Ажилгүйдлийн түвшин, хувиар		6.3	5.5	7.6	4.7	4.6	4.6	3.4	

Эх үүсвэр: Монгол банкны жилийн тайлан 1997, 2000, 2003

* Урьдчилсан гүйцэтгэл

Сүүлийн жилүүдэд эдийн засгийн байдал тогтворжиж, зарим өсөлт гарч, улмаар ядуурлыг бууруулах нөхцлийг бүрдүүлж байгаа хэдий ч ядуурал буураагүй, энэ талаар авч буй арга хэмжээ мэдэгдэхүйц үр дүн өгөхгүй байна.

Монгол Улсын эдийн засгийн цар хүрээ нэмэгдээгүй, үндэсний нийт орлогоор дэлхийд 172, нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоор 167, худалдан авах чадвараар 170 дугаар байрт байгаа нь төр, засгаас авч буй арга хэмжээ, тэдгээрийн үр дүнг эрс сайжруулах шаардлагатайг харуулж байна.

“Амьжиргааны доод түвшний тухай” хуулийг үндэслэн Үндэсний статистикийн газраас амьжиргааны доод түвшинг 5 бүс нутгаар сард 19500-25300 төгрөгөөр тогтоосон бөгөөд энэхүү түвшний 40 хувиас доош орлоготой өрхийг нэн ядуу гэнэ.

Хүснэгт 2

Амьжиргааны доод түвшингийн хэмжээ

(төгрөгөөр)

Бүс нутгийн байршил	2001	2002	2003
Баруун бүс	18200	19200	19500
Зүүн бүс	19900	20200	20500
Төв бүс	19300	19700	19800
Хангайн бүс	18200	19100	19900
Улаанбаатар	23600	24600	25300

Эх үүсвэр: ҮСГ, Статистикийн эмхэтгэл 2001

1995 онд Монголын нийт хүн амын 36.0 хувь ядуу байсан бол 1998 оны байдлаар ядуурлын түвшин 35.6 хувь, үүнээс хотын хүн амын 39.4 хувь, хөдөөгийн хүн амын 32.6 хувь нь ядуу байсан бөгөөд 1995 онтой харьцуулахад зөвхөн Улаанбаатар хотод л ядуурал бага зэрэг буурсан ажээ.

Хүснэгт 3

Ядуурлын үзүүлэлтүүд

	Ядуурлын тохиолдол, P0, %		Ядуурлын хэмжээ, P1, %		Ядуурлын зэрэглэл, P2 (индекс)	
	1995	1998	1995	1998	1995	1998
Хотод	38.5	39.4	12.2	13.9	5.7	7.1
Улаанбаатарт	35.1	34.1	10.4	13.0	4.5	7.4
Хөдөөд	33.1	32.6	8.9	9.8	3.6	4.4
Нийт	36.3	35.6	10.9	11.7	4.8	5.6

Эх үүсвэр: ҮСГ, Амьжиргааны түвшний судалгаа, 1998

Иргэдийн амьжиргааны түвшин тууштай дээшлэхгүй, мөнгөн орлогын өсөлт хангалтгүй, мөнгөн орлогын бүтэц гажигтай хэвээр, өрхийн орлогод ажил хөдөлмөр хийгээд авдаг цалингийн орлого өчүүхэн хувь эзэлсэн хэвээр байгаа нь Монгол улсад иргэдийн амьдралын түвшин доогуур, ядуурал өргөн хүрээтэй байгааг харуулж байна.

Хотын иргэдийн хувьд нийт орлогод арилжаа наймааны орлого нэлээд өндөр хувь эзэлж байна. Харин хөдөөний иргэдийн хувьд хувийн аж ахуй (МАА, газар тариалан)-н орлого өндөр байна.

Нэг өрхийн сарын дундаж нийт болон мөнгөн орлого

оны үнээр (төгрөгөөр)

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	2000	2001	2000	2001	2000	2001
Нийт орлого, бүгд	111119	155207	133579	161155	85994	147264
Мөнгөн орлого, бүгд	102133	123020	130402	148554	70511	104318
Цалин	32459	36200	47927	59522	15154	19546
Тэтгэвэр, тэтгэмж	8929	10609	12322	12660	5132	9155
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	13678	37264	5232	19746	23127	48648
Арилжаа наймаа	18097	19364	23707	28295	11822	13549
Мөнгөн тусламж, бэлэг	2145	5606	3655	10753	456	1652
Зээл	1930	5310	2323	4718	1490	6496
Бусад*	24895	8667	35236	12860	13330	5272
Бусдаас үнэгүй авсан	1987	5422	2617	7714	1281	3930
Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлс	6999	26765	560	4887	14202	39016

Эх үүсвэр: ҮСГ, Статистикийн эмхэтгэл, 2001 оны 11 дүгээр сар

Нэг өрхийн сарын дундаж нийт болон мөнгөн орлогын бүтэц

(Хувиар)

	Улсын дундаж		Хот		Хөдөө	
	2000	2001	2000	2001	2000	2001
Нийт орлого, бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Мөнгөн орлого, бүгд	91.9	79.3	97.6	92.2	82.0	70.8
Цалин	29.2	23.4	35.9	36.8	17.6	13.3
Тэтгэвэр, тэтгэмж	8.0	6.8	9.2	7.9	6.0	6.2
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	12.3	24.0	3.9	12.3	26.9	33.0
Арилжаа наймаа	16.3	12.5	17.7	17.6	13.7	9.2
Мөнгөн тусламж, бэлэг	1.9	3.6	2.7	6.7	0.5	1.1
Зээл	1.7	3.4	1.7	2.9	1.7	4.4
Бусад*	22.4	5.6	26.4	8.0	15.5	3.6
Бусдаас үнэгүй авсан	1.8	3.5	2.0	4.8	1.5	2.7
Өөрийн хувийн аж ахуйгаас хэрэглэсэн хүнсний зүйлс	6.3	17.2	0.4	3.0	16.5	26.5

Эх үүсвэр: ҮСГ, Статистикийн эмхэтгэл, 2001

Зарим салбарын хөгжил, ажлын үр дүн үндсэндээ эмэгтэйчүүдээс хамаарч байна.

Монгол улсын эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүдийн үүрэг роль чухал бөгөөд эмэгтэйчүүд нийт хүн амын 51.0 хувь, хөдөлмөрийн насны хүн амын 51.4 хувь, улс ардын

аж ахуйд ажиллагсдын 49.4 хувь, түүний дотор төрийн өмчит ба төсөвт байгууллагад ажиллагсдын 52.3 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, нөхөрлөл, хоршоонд ажиллагсдын 48.2 хувь, хувьцаат ба хязгаарлагдмал хариуцлагатай компанид ажиллагсдын 50.4 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь нийгмийн баялгийг бүтээхэд эмэгтэйчүүд чухал үүрэгтэйг ил тод харуулж байна.

Хүн амын ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

Хүснэгт 6

	1999		2000		2001		2002	
	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй	Бүгд	Үүнээс эмэгтэй
Хөдөлмөрийн насны хүн ам	1279.3	637.0	1347.4	676.5	1402.8	719.9	1439.2	739.1
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	853.4	408.3	847.6	412.8	872.6	429.7	901.7	447.4
Ажиллагчид*	813.6	386.7	809.0	392.1	832.3	407.8	870.8	430.6
Бүртгэлтэй ажилгүйчүүд	39.8	21.6	38.6	20.7	40.3	21.9	30.9	16.8
Ажиллах хүчний оролцооны түвшин	66.7	64.1	62.9	61.0	62.2	59.7	62.7	60.5
Ажил эрхлэлтийн түвшин	63.6	60.7	60.0	58.0	59.4	56.8	60.5	58.3
Ажилгүйдлийн түвшин	4.7	5.3	4.6	5.0	4.6	5.1	3.4	3.8

Эх үүсвэр: ҮСГ, Хүн амын ажил эрхлэлт, 2002

* Гадаадад гэрээгээр ба хувиараа ажиллагсад, Гадаад хэргийн яамны шугамаар гадаад оронд суугаа хүмүүс ороогүй болно.

Эрэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн түвшин 2002 оны байдлаар эмэгтэйчүүдийнхээс 7.0 хувиар дээгүүр байхад эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс 21.0 хувиар илүү байна. 16 хүртэл насны хүүхдийн 49.7 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байгаа атлаа өндөр настны 55.1 хувь, ажилгүйчүүдийн 54.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Эдгээр нь Монгол улсад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өндөр боловч эрэгтэйчүүдийн хэмжээнээс нэлээд доогуур байгааг харуулж байна.

Зарим салбарын хөгжил, ажлын үр дүн үндсэндээ эмэгтэйчүүдээс хамаарч байдгийг эмэгтэйчүүд багш, эмч нарын бараг 80.0 хувь, шүүгчдийн 60.0 гаруй хувь, их дээд сургуульд суралцагчдын 70 гаруй хувь, боловсролын салбарт ажиллагсдын 64.4 хувь, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын 68.9 хувь, бөөний ба жижиглэн худалдааны салбарт ажиллагсдын 54.4 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт ажиллагсдын 55.3 хувийг тус тус эзэлж байна.

Эрүүл мэндийн байгууллагад ажиллагсад

Үзүүлэлт	1998	2000	2001	2002
Бүгд	29997	31507	32077	33273
үүнээс: эмэгтэй	25031	25284	26059	27384
<i>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь, %</i>	83.5	80.3	81.2	82.3
Их эмч, бүгд	6162	6498	6639	6823
үүнээс: эмэгтэй	4733	4999	5141	5296
<i>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь, %</i>	76.8	76.9	77.4	77.6

Ерөнхий боловсролын сургуулийн зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	1998	2000	2001	2002
Багшийн тоо, мян.хүн	18.5	19.2	20.1	20.7
Эмэгтэй	14.7	15.2	15.9	16.4
<i>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь, %</i>	79.5	79.2	79.1	79.2
Бага ангийн	7.8	7.8	7.6	7.5
Ахлах, дунд ангийн	10.7	11.4	12.5	13.2
1-р ангид элсэгчдийн тоо, мян.хүн	66.9	62.1	58.2	64.0
үүнээс: эмэгтэй	33.1	30.5	28.9	31.5
<i>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь, %</i>	49.5	49.1	49.7	49.2
Төгсөгчдийн тоо, мян.хүн	52.3	49.7	62.3	74.1
үүнээс: өдрөөр	50.4	47.8	60.0	71.8
Эмэгтэй	29.5	28.7	35.3	39.8
<i>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь, %</i>	56.4	57.8	56.7	53.7

Гэвч төр, засгаас эмэгтэйчүүдийн талаар авч буй арга хэмжээний үр дүн хангалтгүй, жендэрийн ялгаатай байдал байсаар байгаа бөгөөд эдийн засгийн боломжийн хүртээмж, төрийн үйлчилгээг хүртэх чадвар, эдийн засаг болон гэр бүлийн хүчирхийлэлд өртөх байдал, улс төрийн хүч чадлаар эмэгтэйчүүд ялгаатай байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо буурахгүй (61.7 мянган өрх), 16 хүртэлх насны хүүхэдтэй, нөхөргүй эмэгтэйчүүдийн тоо (46.3 мянган хүн) цөөрөхгүй, хөдөлмөрийн насны 139.4 мянган эмэгтэй ажил эрхэлдэггүй, шийдвэр гаргах бүх шатны түвшинд эмэгтэйчүүд маш цөөн, нялхсын эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхэд тутамд 29.6 байсаар буй, жил тутам бараг 10.0 мянган эх үр хөндүүлж байна.

Жендэрийн зарим үзүүлэлтүүд

Хүснэгт 9

	1999	2000	2001	2002
Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо	55248	56491	61285	61765
<i>Урьд онтой харьцуулсан өсөлт, хувиар</i>	-	2.2	8.5	0.8
16 хүртэлх насны хүүхэдтэй, гэр бүлгүй эмэгтэйчүүдийн тоо	40653	40060	42416	46298
<i>Урьд онтой харьцуулсан өсөлт, хувиар</i>	-	-1.5	5.9	9.2
Гэрлэсэн хүний тоо	13722	12601	12393	13514
<i>Урьд онтой харьцуулсан өсөлт, хувиар</i>	-1.3	-8.2	-1.7	9.1
Гэрлэлтээ цуцалсан хүний тоо	941	815	650	688
<i>Урьд онтой харьцуулсан өсөлт, хувиар</i>	2.6	-13.4	-20.2	5.8
Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо	49229	48541	49478	46691
<i>Урьд онтой харьцуулсан өсөлт, хувиар</i>	-	-1.4	1.9	-5.6
Төрсөн хүүхдийн тоо	49461	48721	49685	46922
<i>Урьд онтой харьцуулсан өсөлт, хувиар</i>	-	-1.5	2.0	-5.6

Эх үүсвэр: ҮСГ, Статистикийн эмхэтгэл 2002

Сүүлийн 4 жилд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо 11.8 хувиар буюу 6517 өрхөөр, 16 хүртэлх насны хүүхэдтэй, нөхөргүй эмэгтэйчүүд 13.9 хувиар буюу 5645 хүнээр тус тус өссөн нь анхаарал татах асуудал мөн. Гэтэл энэ хугацаанд хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо 5.2 хувиар буюу 2538 хүнээр буурсан байна.

Түүгээр ч барахгүй жил бүр 1000 орчим эмэгтэйчүүд шүүхээр ял шийтгүүлж байна.

Хүснэгт 10

Шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоо

Үзүүлэлт	1999	2000	2001	2002
Бүгд	14255	14234	13581	11357
Эмэгтэй	1016	1005	1088	859
<i>Эмэгтэйчүүдийн эзлэх хувь, %</i>	<i>7.1</i>	<i>7.1</i>	<i>8.0</i>	<i>7.6</i>
16 хүртэлх насны хүүхэд	857	990	1034	983

Эх үүсвэр: ҮСГ, Статистикийн эмхэтгэл 2003

2002 онд нийгмийн халамжийн үйлчилгээгээр нийт 13.8 тэрбум төгрөгийг 160 гаруй мянган хүнд олгосноос 64.0 хувь буюу 8.8 тэрбум төгрөгийн тэтгэмжийг жирэмсний болон амаржсаны, ихэр хүүхдийн, хүүхэд асарсны, нярай хүүхдийн арчилгааны, олон хүүхэдтэй эхийн зэрэг хэлбэрээр 120.0 гаруй мянган эмэгтэйчүүдэд олгожээ. Түүнчлэн нийгмийн халамжийн тэтгэвэр 4.4 тэрбум төгрөгийг нийт 37.3 мянган хүнд олгосноос эмэгтэйчүүд түүний 51.0 хувь буюу 2.3 тэрбум төгрөг авсан гэж тооцвол 2002 оны нийгмийн халамжийн үйлчилгээний нийт зардлын 80.0 гаруй хувийг эмэгтэйчүүдэд зориулсан байна.

Мөн 2002 онд нийгмийн даатгалын сангаас 262.9 мянган хүнд 69.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос 55.1 хувийг эмэгтэйчүүдэд зориулсан гэвэл нийт 140 гаруй мянган эмэгтэйчүүд 38.0 тэрбум төгрөгийн тэтгэвэр авчээ.

Ийнхүү нийгмийн даатгал, нийгмийн халамжийн сангаас 2002 онд зарцуулсан нийт хөрөнгийн 60 гаруй хувийг эмэгтэйчүүд, нярай хүүхдэд зориулсан байна.

Хүснэгт 11

Нийгмийн халамжийн тэтгэмж авсан хүний тоо

(мян.хүн)

Үзүүлэлт	1999	2000	2001	2002
Бүгд	160.0*	110.5	129.1	129.4
Жирэмсэн болон амаржсаны	47.8	46.0	50.6	49.3
Хүүхэд асарсаны	42.6	31.5	53.9	57.1
Ихэр хүүхдийн	0.3	0.4	0.3	0.3
Өнчин хүүхэд үрчлэн авсны	0.3	0.4	0.4	0.5
Нярай хүүхдийн арчилгааны	5.3	3.5	3.3	4.6
Ганц бие хүний оршуулгын	0.01	0.03	0.04	0.04
Олон хүүхэдтэй эхийн	63.7	28.7	20.6	17.5

Эх үүсвэр: НХХЯ, 2002

Хүснэгт 12

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчид, олгосон тэтгэвэр, тэтгэврийн төрөл, хамрагдсан хүний тоо

(Оны эцэст)

Үзүүлэлт		2001	2002
Тэтгэвэр авагчдын тоо, мян.хүн		259.3	262.9
Үүнээс:	Өндөр насны тэтгэвэр авагч	181.4	183.6
	Тахир дутуугийн тэтгэвэр авагч	35.6	37.6
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч	36.6	35.5
	ҮОМШӨ-ний тэтгэвэр авагч	5.7	6.2
Олгосон тэтгэврийн хэмжээ, сая төг		60661.2	68962.5
үүнээс:	Өндөр насны тэтгэвэр	45262.9	51254.8
	Тахир дутуугийн тэтгэвэр	6324.5	7476.0
	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	7006.2	7804.4
	ҮОМШӨ-ний тэтгэвэр	2067.6	2427.3

Эх үүсвэр: НХХЯ-ны судалгааны материал, 2003

Өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувийн жин өндөр байгаа нь үндсэндээ өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд үндэсний үйлдвэрлэлийг сэргээх, нэмэгдүүлэх асуудал зохих ёсоор анхаарагдаагүй хоцорсон, гадаадын зээл, тусламжийн ихэнх хэсэг эхний үед төсвийг тэнцвэржүүлэх, дараа нь дэд бүтэц, нийгмийн арга хэмжээнд зориулагдаж, харин

үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт олигтой хийгдэхгүй байсны сөрөг үр дагавар болж байна.

Сүүлийн 10-аад жилд Монголд хандивлагчид 2.9 тэрбум долларын зээл, тусламж амласны 72.0 хувь буюу 2.1 сая долларын зээл, тусламжийг бодитойгоор авч ашигласан бөгөөд үүний 1.2 тэрбум доллар нь хөнгөлөлттэй зээл, 0.9 тэрбум доллар нь техникийн буцалтгүй тусламж юм. Эдгээрээс 50.0 хувийг дэд бүтцийн салбарт, 20.0 хувийг бүтцийн өөрчлөлтийг дэмжихэд, 10 хувийг нийгмийн үйлчилгээний салбарт, 10.0 хувийг хөдөө аж ахуйд тус тус зориулжээ.

Монгол улс хөгжлийн албан ёсны зээл тусламжаас ихээхэн хамааралтай дэлхийн улс орнуудын эхний 5-д ордог улс болжээ. Шилжилтийн эхний үед буюу 1990-ээд онд хөгжлийн зээл тусламж дотоодын нийт бүтээгдэхүүний 24.0 хувийг эзэлж байжээ. Монгол улс урьд жилүүдэд жилд 200 орчим сая ам.долларын зээл, тусламжийг ашиглаж байсан бол одоо 100 орчим сая ам.доллар болжээ.

Гадаад зээлийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийн жин 2001 оны эцэст зохистой хэмжээ гэж үздэг 60 хувиас хэтэрсэн байна.

Харин гадаад зээлийн өрийн экспортод эзлэх хувь, мөн өрийн үйлчилгээний ДНБ болон экспорт, төсөвт эзлэх хувийн жин зохистой гэж үздэг хэмжээнд байна.

Зээлийн ашиглалт, зарцуулалтыг бүртгэх, хянах, зээлийн ашиглалт, төлбөрийн талаар хариуцлага хүлээлгэх асуудал урсгалаар шахуу явж, зохих ёсны удирдлага, зохицуулалт дутагдаж байсныг засах талаар сүүлийн жилүүдэд зарим ахиц гарч байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Тухайлбал, Санхүү, эдийн засгийн яаманд Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газар болон Төрийн сангийн газрыг Өрийн удирдлагын хэлтэстэйгээр байгуулж ажиллуулснаар гадаадын зээл, тусламжийн нэгдсэн бүртгэл, хяналт, тооцоотой болсон байна. Тухайлбал, зээл, түүний төлбөрийн бүрэн мэдээллийг 2040 он хүртэл хугацааг хамруулан статистик мэдээллийн баазтай болжээ.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал, түүнтэй холбогдуулан жендэр, ядуурлын асуудлыг Монгол улсын төр засаг, нийгэм-эдийн засгийн салбар, олон нийт ер нь аль ч бүтцэд бүгд л анхаарч, эдгээртэй холбогдсон асуудлыг авч үздэг, бодлого боловсруулан хэрэгжүүлэх зэргээр тодорхой хэмжээгээр тусгалаа олжээ.

Монгол Улсын Их Хуралд гэхэд эдгээр асуудлыг 3 байнгын хороо, эмэгтэй парламентчдын бүлэгт үндсэндээ байнга авч үздэг, бусад байнгын хороод ч анхааралдаа байлгаж, ялангуяа хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох арга хэмжээ авсаар иржээ.

Эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд

Албан тушаал	1999		2002	
	Нийт	Эмэгтэйчүүд	Нийт	Эмэгтэйчүүд
УИХ-ын гишүүн	76	8	76	9
УИХ-ын байнгын хорооны дарга	7	2	7	1
Засгийн газрын гишүүн	10	1	10	
Аймаг, нийслэл, сумын Засаг дарга	360	9	360	
Элчин сайд	28		30	1
Аймаг, хотын ИТХТ-ийн дарга	22		22	1
Дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга	10		23	4

Монгол Улсын Засгийн газар, яам, агентлагуудаас гадна жендэр, ядуурлын асуудал хариуцсан Засгийн газрын 2 зөвлөл, 1 хороо ажиллаж байна.

Жендэр, ядуурлын асуудлыг төрийн бус байгууллагууд ч нэлээд анхаарч эдгээр асуудлаар холбоо, хөдөлгөөн, эвсэл, сан, төв зэргийг байгуулан ажиллаж байгаагийн дотор эмэгтэйчүүдийн 78 төрийн тус байгууллага үйл ажиллагаагаа эмэгтэйчүүдийн асуудалд голчлон чиглүүлэн явуулж байна.

Зээл, тусламжийн асуудалд олон улсын байгууллагууд, хандивлагч орнууд анхаарч төлөөллийн байгууллага, агентлаг, сангууд ажиллуулж байна. Жендэр, ядуурлын асуудлыг нэлээд анхаарч, семинар, бага хурал зохиох, сургалт явуулах, ном, товхимол, танилцуулга, гарын авлага гаргах зэргээр зарим байгууллага, хандивлагч орон, ялангуяа НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан, Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг зэрэг байгууллагуудыг дурьдаж байна.


Гадаадын зээл, тусламжийн асуудлын удирдлага, бүтцийг авч үзэхэд:


- УИХ (Байнгын хороод, бүлэг);
- Засгийн газар (хороо, зөвлөл);
- Гадаадын зээл, тусламжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (СЭЗЯ, төслийн нэгжүүд, ГХЯ);
- Зээл, тусламжийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагууд (салбарын яам, агентлагууд, тодорхой чиглэлийн нэгжүүд - газар, хэлтэс, зөвлөл, төв г.м.);
- Жендэрийн асуудал хариуцсан төрийн бус байгууллагууд (төв, холбоо, хөдөлгөөн, сан, эвсэл г.м.);

- Хандивлагч гадаад орон, олон улсын байгууллагын төлөөлөл (ЭСЯ, хөтөлбөр, сан, агентлаг, газар, төв г.м.);
- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагын нэгжүүд буюу зохицуулагчид (нэгж, төв, сан г.м.);
- Төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчид (зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжих тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулалтаар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагууд);
- Дамжуулан зээлдүүлэгчид (Монголбанк, арилжааны банкууд, ББСБ);
- Төсөл, арга хэмжээний ашиг хүртэгчид (Тодорхой төсөл, арга хэмжээгээр олгосон хөрөнгийг зарцуулан хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүс, сургалтын байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, хоршоолол, нөхөрлөл г.м.).

Зураг 1

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбар дахь гадаадын зээл, тусламжийн зарцуулалтын жендэрийн болон ядуурлын асуудлын удирдлага, зохион байгуулалтын бүтэц





Төрийн бус байгууллагууд




Зээл, тусламж хандивлагч орон, олон улсын байгууллага

Хандивлагч орнуудын ЭСЯ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр	НҮБ-ын Хүн амын сан	НҮБ-ын Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан	НҮБ-ын Хүүхдийн сан
ОУВС-ийн суурин төлөөлөгчийн газар	Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газар	АХБ-ны суурин төлөөлөгчийн газар	ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны байгууллага (GTZ)	АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг
ХАА-г хөгжүүлэх олон улсын сан	Тасис	Шведийн олон улсын хөгжлийн сан	ХАА-г хөгжүүлэх олон улсын сан	Нордикийн хөгжлийн сан
Адра	Дэлхийн зөн	Ази-Номхон далайн орнуудын хөгжлийн төв	СИДА	Английн түншлэлийн хөтөлбөр
Канад сан		Говийн санаачилга		

Гадаадын зээл, тусламжийн төсөл хэрэгжүүлэгчийн нэгжүүд

Ядуурлын судалгаа, хөдөл-мөр эрхлэлтийг дэмжих төслийн нэгж	Нийгмийн хамгааллын салбар-ыг хөгжүүлэх төслийн нэгж	Нийгмийн хамгааллын салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийн нэгж	Тахир дутуу иргэ-дийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн нэгж	Бэлчээрийн н эрсдэл ба ядуурал төслийн нэгж
Жендерийн мэдрэмжтэй төсөв боловсруулах төслийн нэгж	Монголын хөгжил ба ядуурал төслийн нэгж	Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн нэгж	ХАА-н салбарын хөгжлийн төслийг удирдах нэгж	Бэлчээрийн н тогтвортой менежмент төслийн нэгж
Газар тариалан-МАА хосолсон үйлдвэрлэл төслийн нэгж	Эмзэг бүлгийн орлого бий болгох сан (Эргэлтийн сан)	ХАА-г хөгжүүлэх олон улсын сан	Нэн ядуу иргэдэд туслах сан	



Нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн салбарт хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр хандивлагчдын зээл, тусламжаар 1996-2003 онд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж буй 321 төслөөс сонголт хийхдээ дараахь зарчим баримталсан болно. Үүнд:

- Эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад тухайн төслийн зориулалт;
- Ядуурлын тодорхой арга хэмжээнд чиглэсэн байдал;
- Жендэр, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнд зориулагдсан байдал;
- Улс ардын аж ахуйн салбар, түүний дотор хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын ядуурлыг бууруулах, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн байдал;
- Төслийг хэрэгжүүлж байгаа хугацаа, түүнээс хамаарч төслийн үр дүнгээр дүгнэлт хийх боломж бий эсэх;
- Ядуурал, жендэрт чиглэсэн нийт төсөл, тэдгээрийн зориулалт, хэрэгжилтийн төлөөлөл болж чадах эсэх зэргийг харгалзан үзлээ.

Төслүүдийн хэрэгжилтийн явцаас харахад жендэрийн болон ядуурлын нөлөөлөлтэй холбогдолтой мэдээ материал болон ойлголт бүрхэг байна.

Зээлийн хөрөнгөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь зөвхөн сургалт, семинарын хэлбэрээр хязгаарлагдах бус төсөл нь иргэдэд, ялангуяа эмзэг бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийгмийн хамгааллын салбарын үйлчилгээг сайжруулахад бодит нөлөөлөл үзүүлэх, ажлын байрыг бий болгох хүрээнд шаардлагатай түүхий эд, материал, тоног төхөөрөмж худалдан авч өгөх, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийг олж өгөхөд зуучлах зэрэг арга хэмжээнд зарцуулбал төслийн зорилт бодитой биелэх боломжтой гэж үзэж байна.

Хэрэгжиж буй төслүүдээс жишээ болгон “Эрхийн бичиг” хөтөлбөрийн хэрэгжилт, “Жижиг зээлийн эргэлтийн сан”-гийн байдлыг судалсан тайланг дор үзүүллээ.

Эрхийн бичиг хөтөлбөрийн сургалтад хамрагдсан хөдөлмөр эрхлэгчид болон ажиллагчдын дунд судалгаа хийж үзэхэд, тэдгээрийн 70 гаруй хувьд нь сургалт үр дүнтэй болжээ.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр “Эрхийн бичгийн сургалт” хөтөлбөр 2002 оны 5-11 дүгээр сарын хооронд 6 сарын хугацаатай хэрэгжсэн байна. Туршилтын хөтөлбөрийн гол зорилго нь сургалтын байгууллагуудын хооронд шударга өрсөлдөөнийг бий болгож чанартай сургах, энэ үндсэн дээр ажил олгогчдын хэрэгцээг хангахуйц ур чадвартай ажилчдыг бэлтгэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэжээ. Туршилтын төсөл хэрэгжих явцад 1967 хүнд 6873 эрхийн бичгийг олгож нөхөн төлбөрт нь 110 мянган ам.доллар зарцуулжээ. Хөтөлбөрт нийслэлийн бүх дүүрэг хамрагдаж, эрхийн бичиг авсан 1967 хүнээс 77.0 хувь буюу 1514 нь ажилгүйчүүд, 4.0 хувь буюу 78 нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 19.0 хувь буюу 373 нь ажиллагсад байжээ. Ур чадварын сургалтад хамрагдсан иргэдийн 76.0 хувь буюу 1494 нь эмэгтэйчүүд байгаа нь нэг талаас эмэгтэйчүүдийн сурч боловсрох хүсэл эрмэлзлэл өндөр байгаа, нөгөө талаас ажилгүйчүүдийн дотор эмэгтэйчүүд нэлээд илүү байгаатай холбоотой байж болох юм. Эдгээрийн 77.0 хувь буюу 1514 ажилгүй иргэн уг хөтөлбөрт хамрагдсан нь сургалтын хөтөлбөрөөр ажилгүй, орлогогүй, эмзэг бүлгийн иргэдэд ур чадвар эзэмшүүлэх, улмаар ажлын байртай болгож амьжиргааг нь дээшлүүлэх, орлогыг нь нэмэгдүүлэх зорилготой нийцэж байна гэж дүгнэж болох юм.

**Эрхийн бичиг сургалтад хамрагдсан ажилгүйчүүдийн
дунд явуулсан судалгааны дүн**

1	Асуулт	Тоо	Хувь
1.	Бүх хамрагдсан хүн	1967	100.0
	Үүнээс: ажилгүйчүүд	1514	77.0
а.	Ажилд орсон	424	28.0
б.	Хувийн аж ахуй эрхлэх гэж байгаа	363	18.5
в.	Ойрын хугацаанд ажилд орох нөхцөл бүрдсэн	242	16.0
г.	Гэр бүлдээ үйлчилгээ үзүүлэх замаар өрхийн зардлаа хэмнэж байгаа	227	15.0
д.	Бусад ахицтай үр нөлөө гарсан	181	12.0
е.	Үр нөлөөгүй гэж үзсэн	75	5.0

“Эрхийн бичиг” сургалтад хамрагдсан ажилгүйчүүдийн дунд явуулсан судалгаанаас харахад, багагүй хувь нь ажилд орсон, хувийн аж ахуй эрхлэх болон ойрын хугацаанд ажил олж хийх нөхцөл бүрдсэн, гэр бүл, ойр дотнын хүмүүст эзэмшсэн ур чадварынхаа дагуу үйлчилгээ үзүүлэн зардал хэмнэж байгаа гэж хариулснаас үзэхэд ажилгүй иргэдийн хувьд “Эрхийн бичиг сургалтын хөтөлбөр” тодорхой үр өгөөж өгсөн нь харагдаж байна.

**Эрхийн бичиг сургалтад хамрагдсан ажиллагчдын
дунд хийсэн судалгааны дүн**

1	Асуулт	Тоо	Хувь
1.	Хамрагдсан бүгд	1967	100.0
2.	Үүнээс: Ажиллагчид	374	19.0
а.	Ажлын байр баталгаатай болсон	101	36.0
б.	Ажлаа өмнөхөөсөө сайжруулсан	146	39.0
в.	Бусад ахицтай үр нөлөө гарсан	97	26.0
г.	Үр нөлөөгүй	30	8.0

Судалгааны үр дүнгээс үзэхэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тухайд “Орлого олох баталгаа нь нэмэгдэж чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн, ажлын байр нь баталгаатай болсон, өмнөхөөсөө дээр нөхцөл цалинтай ажилд орсон” гэж хариулсан нь ямар ч хүн зах зээл дээр өрсөлдөхүйц ур чадвар эзэмшиж, ур чадвараа дээшлүүлж байвал амьдралын баталгаа хангагдах, амьдралд нааштай ахицтай өөрчлөлт гарахад шууд нөлөөлж байна гэж үзэж болох юм.

**“Эрхийн бичиг” сургалтад хамрагдсан хувиараа хөдөлмөр
эрхлэгчдийн дунд явуулсан судалгааны дүн**

1	Асуулт	Тоо	Хувь
1.	Хамрагдсан бүгд	1967	100.0
2.	Үүнээс: хувиараа хөдөлмөр эрхлэгчид	79	4.0
а.	Бизнес нь сайжирсан	25	32.0
б.	Орлого удахгүй нэмэгдэнэ	31	4.0
в.	Бусад ахицтай үр нөлөө гарсан	16	21.0
г.	Үр нөлөөгүй	6	7.0

Эрхийн бичиг сургалтын туршилтын төсөл нь иргэд, хамрагдагсад зохих сайн нөлөө үзүүлсний зэрэгцээ сургалтын байгууллагуудын тоо өссөн, сургалтын хөтөлбөр модулийн хэлбэрт шилжсэн, хөндлөнгийн хяналт тогтмолжсон, сонголт өргөжиж, суралцах нэр төрөл олширсон, сурталчилгаа, мэдээлэл сайжирсан зэрэг өөрчлөлтүүдийг бий болгосноороо төсөл зорилтоо үндсэнд нь хангаж байна.

Туршилтын төсөл хэрэгжих хугацаанд ашиг хүртэгсдийн 76.0 хувь буюу 1494 нь эмэгтэйчүүд, 77.0 хувь буюу 1514 нь ажилгүйчүүд байсан бол дараагийн шат болох Хөдөлмөр эрхлэлтийн газраас хариуцан явуулж буй сургалтад хамрагдагсад нь 100.0 хувь ажилгүйчүүд, 70.5 хувь нь эмэгтэйчүүд, 83.0 хувь нь 16-35 насны залуучууд, 81.0 хувь нь бүрэн ба бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн хөдөлмөр эрхлэлтийн албадын дарга, сургалтын мэргэжилтнүүд “Эрхийн бичиг” сургалтын хөтөлбөрийн давуу бөгөөд сул тал, цаашид анхаарах асуудлаар санал солилцоход:

- “Эрхийн бичиг” сургалтын хөтөлбөр хэрэгжсэнээр сургалтын байгууллагын тоо нэмэгдэж, шударга өрсөлдөөн бий болж, суралцах иргэн чөлөөтэй сонголт хийх боломжтой болсон;
- Сургалтын чанарт хяналт тавих, сурталчилгаа мэдээлэл илүү ахицтай болох, зөвлөгөө өгөх үйлчилгээ хөгжих хандлага бий болсон зэрэг зөрөг талууд гарснаас гадна
- Сургалтын хөтөлбөрийг хэт жижигрүүлэн олшруулсан;
- Хөдөлмөр эрхлэлтийн албадаас сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналт суларсан;
- Ажилгүй иргэд Хөдөлмөр эрхлэлтийн алба, сургалтын байгууллагын хооронд олон удаа явж чирэгдэл үүсэх явдал гарсан;

- Эрхийн бичгээр олгож буй санхүүгийн татаасыг ажилгүйчүүд, ядуучууд, эмзэг бүлгийнхэн нэлээд давуу ашиглаж, харин ажиллагсад, хувиараа хөдөлмөр эрхлэгчид харьцангуй цөөн ашигласан” гэх зэрэг дутагдалтай талууд гарсан гэж дүгнэж байна.

Харин хөтөлбөрт хамрагдсан иргэдийн орлого хэрхэн нэмэгдсэн талаархи судалгаа мэдээлэл, үүнийг гаргах арга журам, үнэлгээний үзүүлэлт байхгүй байна. Үүний хамт сургалтад хамрагдагсдын дунд явуулсан судалгаагаар хэдийгээр олон биш ч тэдний 7.0-10.0 хувь нь сургалт “үр нөлөөгүй” гэсэн үнэлгээ өгсөн байна.

ЯБҮХ-ийн хүрээнд 1996-2000 онд хэрэгжсэн Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС), Эмзэг бүлгийн орлого бий болгох сан (ЭБОББС), Эмэгтэйчүүдийн хөгжлийн сан (ЭХС)-аас орлого бий болгох чиглэлийн зээлийг орон нутагт олгож эхэлжээ. Уг зээлийн хүрээнд бүх сум, дүүрэгт ЯБЗ-өөр дамжуулан 3.0 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд зээлийн эргэн төлөлтөөс дахин зээл олгосноор давхардсан тоогоор нийтдээ 5.87 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Монгол улсын Засгийн газар, НҮБХХ, Шведийн олон улсын хөгжлийн агентлагаас санхүүжүүлж байгаа “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төслийн хүрээнд зээлийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээ авсны үндсэн дээр ЯБҮХ-ийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлт 2001 оны эцсийн байдлаар 51.1 хувьтай байсан бол 2002 оны эцэст улсын хэмжээнд 63.0 хувьтай болж өссөн байна.

Зээлийн бодит үлдэгдэл, эргэн төлөлт, нийт хөрөнгийн хэмжээ болон цаашид авах арга хэмжээг тодорхойлохын тулд 2003 оны 1-3 дугаар сард бүх аймаг, нийслэл, сум, дүүргийн ӨАЧД Зөвлөлөөс зээлийн эргэлтийн сангийн судалгааг гаргажээ.

Зээлийн эргэлтийн сангийн ашиглалтын байдал

Аймаг/дүүрэг	Нийт олгосон зээлийн хэмжээ (мян.төг)	2001 оны байдлаар эргэн төлөлт, %	2002 оны байдлаар эргэн төлөлт, %
Архангай	416393	72.5	78.8
Баян-Өлгий	223432	33.73	36.06
Баянхонгор	144783	45.59	63.72
Булган	168083	79.36	73.71
Говь-Алтай	170109	52.16	54.62
Дорноговь	522372	87.17	91.05
Дорнод	206033	53.09	55.17
Дундговь	170027	59.95	67.40
Завхан	220983	49.06	57.73
Өвөрхангай	484431	71.06	86.51
Өмнөговь	222077	86.21	77.95
Сүхбаатар	192594	65.33	73.81
Сэлэнгэ	72198	45.56	53.86
Төв	178498	37.15	56.40
Увс	181458	37.43	51.85
Ховд	131351	54.62	45.92
Хөвсгөл	215947	44.26	58.82
Хэнтий	153947	74.88	86.78
Дархан-Уул	327046	28.05	33.63
Орхон	124430	25.27	27.23
Говьсүмбэр	100701	77.40	79.53
Баянгол дүүрэг	132497	24.52	20.42
Баянзүрх дүүрэг	183027	70.59	84.26
Сонгинохайрхан дүүрэг	271625	36.88	40.99
Сүхбаатар дүүрэг	145314	48.93	58.71
Хан-Уул дүүрэг	192463	42.76	44.56
Чингэлтэй дүүрэг	121237	80.87	77.57
Налайх дүүрэг	121871	47.80	37.87
Багануур дүүрэг	96603	68.11	68.63
Багахангай дүүрэг	29365	41.07	37.77
Улсын хэмжээнд	-	51.16	63.04

Аймаг, дүүргийн хэмжээнд үзэхэд, зээлийн эргэн төлөлт Баянгол дүүрэгт 20.4 хувь, Орхон аймагт 27.2 хувь, Дархан-Уул аймагт 33.6 хувь, Багахангай дүүрэгт 34.77 хувь буюу улсын дунджаас ихээхэн доогуур байхад Дорноговь аймагт 91.0 хувь, Хэнтий аймагт 86.8 хувь, Өвөрхангай аймагт 86.5 хувь Баянзүрх дүүрэгт 84.3 хувьтай байна.

Судалгаанаас үзэхэд, Архангай аймгийн Өгийнуур сум, Баянзүрх дүүргийн 12-р хороо, Баянхонгор аймгийн Галуут сум, Говь-Алтай аймгийн Дарви, Тонхил, Төгрөг, Чандмань сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр тосгон, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум, Төв

аймгийн Лүн, Их-Уул сум, Хөвсгөл аймгийн Ханх, Цагаан-Үүр сум, Чингэлтэй дүүргийн 2-р хороо зэрэг 15 сум, хорооны зээлийн эргэн төлөлт 100.0 хувьтай сайн байхад зарим сумдад, тухайлбал, Дорноговь аймгийн Иххэт, Завхан аймгийн Баянтэс, Дөрвөлжин, Цагаанчулуут, Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын зээлийн эргэн төлөлт маш хангалтгүй 2.0 хүртэл хувьтай байна.

Олон улсын санхүүгийн байгууллага, гадаад орны Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хувийн хэвшлийг хөгжүүлэх, хөдөө орон нутгийн санхүүжилт, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, орон сууцны санхүүжилт зэрэг эдийн засаг, нийгмийн чухал ач холбогдолтой тодорхой төслүүд Монголбанкаар дамжин хэрэгжиж байна.

Дамжуулан зээлдүүлэх төслийн хэрэгжилтийг төсөл тус бүрээр оролцогч санхүүгийн байгууллагаар харуулбал:

Хүснэгт 18

	<i>Байгууллагын нэр</i>	<i>Төслийн нэр</i>	<i>Оролцогч санхүүгийн байгууллага</i>
1.	Азийн хөгжлийн банк	ХАА-н салбарыг хөгжүүлэх	Хадгаламж банк Монгол шуудан банк ХААН банк
2.	Азийн хөгжлийн банк	Ажлын байр нэмэгдүүлэх	Голомт банк Зоос банк Эрэл банк Тээвэр хөгжлийн банк
3.	Дэлхийн банк	Хувийн хэвшлийг хөгжүүлэх	Худалдаа хөгжлийн банк Голомт банк Зоос банк

Монгол банкаар дамжуулан хэрэгжүүлж буй Азийн хөгжлийн банкны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх зорилготой “Ажлын байр нэмэгдүүлэх” төсөл хэрэгжсэнээр 2817 ажлын байр шинээр бий болсон нь ядуурлыг бууруулахад зохих нөлөө үзүүлснийг харуулж байна.

Хүснэгт 19

“Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хэрэгжилт

Банкны нэр	Зээлдэгчийн тоо	Олгосон зээлийн дүн, сая.төг	Үлдэгдэл, сая.төг	Хүүгийн Хэмжээ	Нэмэгдсэн ажлын байр
Тээвэр хөгжлийн банк	150	150.0	150.0	сарын 2.9%	150
Зоос банк	110	1483.5	850.0	сарын 2.5%	676
Голомт банк	248	2185.4	1024.0	сарын 2.2%	1265
Эрэл банк	110	799.0	386.3	сарын 2.5%	726
ДҮН	618	4019.4	2410.3		2817

Эх үүсвэр: Монголбанкны танилцуулга

Давтан зээл олгохдоо өмнөх зээлээ тогтоосон хугацаанд нь төлсөн, зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн байж, 3-5 ажлын байр шинээр бий болгосон байх шаардлагыг хангасан байх ёстой. Зээлийн хугацааны хувьд эхний зээлийн хугацаа 1 жил хүртэл, давтан зээл олгохдоо зээлдэгчийн үйлдвэрлэл, үйлчилгээний онцлогийг харгалзан хугацааг 6 сараар нэмэгдүүлэх буюу 1.6 жилээр тогтоож болно.

Энэ зээлийг ямар хүмүүс ашигласан, түүний үр дүн юу болох, ядуурал, жендэрт хэрхэн нөлөөлсөн зэрэг мэдээ, мэдээлэл байхгүй, банкуудад ийм төрлийн мэдээлэл дутмаг байна.

Голомт банкаар дамжуулан хэрэгжүүлж буй Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх” төсөл хэрэгжиж эхэлснээс хойш “Голомт” банк төслийн эх үүсвэрээр 308 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2407.1 сая төгрөгийн зээлийг олгосноос 125.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.

Төслийг Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотод хэрэгжүүлэн нийт 247 иргэн, 118 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсанаас 90 зээлдэгчид нийт 882.0 сая төгрөгийн зээлийг давтан олгосон бөгөөд төслийг хэрэгжүүлсний үр дүнд 1600 гаруй ажлын байр шинээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 20

“Ажлын байр нэмэгдүүлэх” төслийн хэрэгжилт, Улаанбаатар хот

(мян.төгрөгөөр)

1			2001		2002		2003 оны III улирал			
			Анхдагч	Давтан	Анхдагч	Давтан	Анхдагч	Давтан		
1.	Зээлийн хүү (сарын)		2.2%	2.2%	2.2%	2.2%	2.2%	2.2%		
2.	Олгосон зээл		тоо	103	99	38	26	42		
			дүн	718200.0	748000.0	437000.0	185900.0	318000.0		
	үүнээс:		Иргэн		тоо	68	78	27	20	32
			ААНБ		тоо	35	21	11	6	10
			Иргэн		дүн	431900.0	569000.0	307000.0	137900.0	234000.0
			ААНБ		дүн	286300.0	179000.0	130000.0	48000.0	84000.0
3.	Зээлийн өрийн үлдэгдэл		Иргэн		тоо	66	65	21	58	22
			ААНБ		тоо	35	25	13	10.0	16
			Иргэн		дүн	401780.0	369185.0	223400.0	212979.3	395000.5
			ААНБ		дүн	229320.0	161813.91	127450.0	68168.0	161024.8
4.	Монголбанкнаас авсан эх үүсвэр		дүн	785800.0	1024000.0		1024000.0	1024000.0		
5.	Эх үүсвэрийн үлдэгдэл		дүн	29500.0	52631.76		43841.0			
6.	Зээлийн зориулалт (салбар)	үйлдвэрлэл	дүн	446720.4	694410.0		309082.2			
		үйлдвэрлэлийн бус	дүн	271479.6	490590.0		528090.4			

Эх үүсвэр: Голом банк, 2004

Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциациас хэрэгжүүлж буй “Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл”ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Голомт” банк нийт 24 зээлдэгч, Худалдаа хөгжлийн банк 7 зээлдэгчид үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар зээлийг олгосон байна.

Хүснэгт 21

Хувийн хэвшлийг хөгжүүлэх төслийн хэрэгжилт

Банк	Мөнгөний нэгж	Олгосон	Төлсөн	Зээлийн өрийн үлдэгдэл	Хүүгийн хэмжээ, жилийн
Голомт банк	USD мян.	2944.6	265.8	2678.8	11.0%
	MNT сая	1882.6	66.1	1816.5	18.0%
ХХБ	USD мян.	1315.2	179.8	1135.4	9.5%
	MNT сая	1277.3	-	1277.3	9.5%
Дүн	USD мян.	4259.8	445.6	3814.2	
	MNT сая	3159.9	66.1	3093.8	

Эх үүсвэр: Төслийн баг

Зоос банкаар дамжуулан хэрэгжүүлж буй төслүүдэд нийтдээ 609 зээлдэгч иргэд, байгууллага хамрагдсанаас 71 зээлдэгчдэд нийт 812.7 сая төгрөгийн зээл (Хавсралт 1)-ийг давтан олгосон байна.

Бүтцийн хувьд зээлийн 24.2 хувийг Ажлын байр нэмэгдүүлэх төсөл, 27.5 хувийг Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл, 38.9 хувийг Хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх төсөл, 2.9 хувийг Орон сууцны төсөл, 6.5 хувийг Бичил санхүүгийн зээл (Хавсралт) зээлж байна.

Бичил санхүүгийн төслийн зээлээр орон нутаг дахь бага дунд орлоготой иргэд, малчдын үйл ажиллагааг дэмжих, ядуурлыг бууруулах зорилготой арга хэмжээг санхүүжүүлжээ гэж үзэж болохоор байна. Энэ төсөлд нийтдээ орон нутгийн 159 зээлдэгч байгаа нь бүгд ядуу болон бага орлоготой зээлдэгчид байна. Төсөлд хамрагдагсдын 20.1 хувь нь малчин, үлдэх 79.9 хувь нь ядуу болон бага дунд орлоготой зээлдэгч байна. Үүний 54.7 хувийг эмэгтэйчүүд, 45.3 хувийг эрэгтэйчүүд (Зураг 2) зээлж байна. Мөн тухайн зээлээс ашиг хүртэх өрхийн гишүүдийн тоог судалж үзэхэд, эмэгтэй зээлдэгч нь дунджаар 5 хүн, эрэгтэй зээлдэгч дунджаар 4 хүн тэжээж байна. Энэ нь өрх толгойлсон олон хүүхэдтэй эмэгтэйчүүд олон байгааг харуулж байна.


Зураг 2



Насны бүтцийн хувьд авч үзвэл 22-72 насны хүмүүс байгаагаас, 30-50 насны эмэгтэйчүүд нийт зээлдэгчдийн 28.9 хувь, эмэгтэй нийт зээлдэгчдийн 52.9 хувийг эзэлж байна.

Авч буй зээлийн хэмжээний хувьд авч үзвэл нэг эмэгтэй зээлдэгчид дунджаар 1297.8 мянган төгрөг, эрэгтэй зээлдэгчид 1.224.7 мянган төгрөг байна.

Зураг 3



Судалгаанаас үзэхэд хөдөө орон нутагт эмэгтэйчүүд илүүтэйгээр банктай харилцаж байна. Мөн түүнчлэн ар гэрээ тэжээгчийн хувьд авч үзвэл эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс нэг хүнээр илүүтэй гэр бүлээ тэжээж байгаа нь харагдаж байна.

Нийгэм, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэхэд төслийн зээлийн хэрэгцээ, шаардлага орон нутагт өндөр байгаа нь харагдаж байна.

СУДАЛГААНД ҮНДЭСЛЭСЭН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

- Манай орны эдийн засаг, нийгмийн хөгжилтэй холбогдолтой мэдээллийг гаргадаг Үндэсний статистикийн газарт зээл, тусламжийн хэрэгжилт, жендэрийн болон ядуурлын талаар мэдээлэл хомс, бараг байхгүй, улсын болон орон нутгийн төсвөөс, зээл, тусламжийн төслөөс ашиг хүртэгчид хэн бэ? амьжиргааны ямар түвшний хүмүүс яаж ашиг хүртэж, ямар байдалтай байгаад ямар байдалтай болов, нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хэн хэрхэн хүртэж байна вэ? гэх мэт ядуурал, жендэртэй холбогдолтой статистик мэдээллийг бүрдүүлэх
- Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд НХХЯ-ны харьяалалд бүгд байхгүй байгаагаас үр дүнг нэгтгэн тооцох, судалгаа явуулах, дүгнэлт гаргахад бэрхшээлтэй байгаа тул зээл, тусламжийн төслийг тухайн асуудал хариуцсан яам нь хэрэгжүүлж, гүйцэтгэл, үр дүнг ч тэр яам хариуцдаг байх
- Хандивлагчдын зээл, тусламжаас хэн ашиг хүртэж байна, ашиг хүртэгчдийн амьжиргааны байдал ямар байна вэ? Зээл, тусламжийн үр дүнд хэрхэн дээшлэв, өөрчлөгдөв гэсэн судалгаа, тооцоо гардаггүй өмнөх байдлаас сургамж авч, дараагийн зээл, тусламжийг хэрхэн зарцуулах, хэнд чиглүүлэх, үр дүнг нь яаж тооцох вэ? гэдэг нарийвчилсан судалгааны үр дүнгийн үзүүлэлтүүдийг төслийн баримт бичиг боловсруулах үеэс гаргаж, гүйцэтгэлийг хагас жил, жилээр гарган дүгнэлт хийж нийтэд мэдээлдэг болох
- Салбараар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнг тооцоход шаардагдах нэгдсэн мэдээ, тайлангийн маягт гаргаж албан ёсоор хөтлүүлдэг, түүнийг албан ёсны статистикийн мэдээнд оруулах
- Төсөл бүрээс үр шим/ашиг хүртэгчид, төсөлд хамрагдсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, өрхийн амьжиргааны түвшин хэрхэн дээшилсэн талаарх судалгааны маягтыг “Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай” хуулийг үндэслэн СЭЗЯ, ҮСГ болон холбогдох яамд хамтран боловсруулж мөрдүүлэх
- Яам, агентлагуудын зээл, тусламжийн асуудлыг хариуцдаг албадын мэдээллийн сан, программ хангамж нь хоорондоо өөр өөр байгааг анхаарч, бүртгэл тооцоо, статистик мэдээллийн нэгдсэн бодлого загварыг тогтоож мөрдүүлэх нь зээл, тусламжийн ашиглалт, зарцуулалт, үр дүнг тооцох

- Ядуурлыг бууруулах, жендэрийн тэгш байдлыг хангахын тулд хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх асуудлыг эрхэм зорилго болгох, нийгмийн хамгааллын арга хэмжээг тэргүүний чухал зорилт болгон тавих, энэ талаар Монголын төр, засаг шаардлага, хэрэгцээгээ тодорхойлж, хөгжлийн стратеги, хэтийн чиглэл, улсын төсөв, хөрөнгө оруулалтын бодлоготой уялдуулан хандивлагч нарт ханддаг байх

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй “ _____ ”
 (төслийн нэр)
 төслийн хэрэгжилтийн тухай мэдээ, өссөн дүнгээр

Үзүүлэлт			... оны ...-р сарын ...-ны байдлаар	
			Төсөл	Гүйцэтгэл
Төсөвт өртөг	Хандивлагч			
	Засгийн газар			
Зориулалт	Хандивлагч			
	Засгийн газар			
Үүнээс:	Удирдлага	Бүгд		
		Хувь		
	Хөрөнгө оруулалт	Бүгд		
		Хувь		
	Ядуурлыг бууруулах арга хэмжээ	Бүгд		
		Хувь		
	Техник тоног төхөөрөмж	Бүгд		
		Хувь		
	Жендэрийн арга хэмжээнд	Бүгд		
		Хувь		
Ашиг хүртэгчид	Эр			
	Эм			
	Үүнээс: Өрх толгойлсон эмэгтэй			
Ашиг хүртэгчдийн орлого /Мөнгөн дүнгээр/	Төслөөс ашиг хүртэхийн өмнө	Эр		
		Эм		
		Үүнээс: Өрх толгойлсон эмэгтэй		
	Ашиг хүртэж эхэлснээс хойш	Эр		
		Эм		
		Үүнээс: Өрх толгойлсон эмэгтэй		
Шинээр бий болгосон ажлын байрны тоо				

Хавсралт 1

БИЧИЛ САНХҮҮГИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

	Зээлдэгчийн тоо	Үүнээс:		Олгосон зээлийн дүн	Ашиг хүртэгсэд (өрхийн)	Зээлдэгчийн нас		
		Ядуу болон бага орлоготой	Малчин			30 хүртэл насны	30-50 хооронд	50-иас дээш
Эмэгтэй	87	80	7	112,388.4	5.1	15	46	26
Эрэгтэй	72	47	25	88,181.6	4.48	23	26	23

Хавсралт 2

“ЗООС” БАНКААР ДАМЖУУЛАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛИЙН ЯВЦ, ХЭРЭГЖИЛТ

/Сая төгрөгөөр/

Д/д	Төслийн нэр	Олгосон зээл		Үүнээс: төлөгдсөн зээл	Төслийн санхүүжил-тээр олгосон нь	Давтан олгосон зээл		Эцсийн үлдэгдэл	
		Дүн	Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо
1.	<u>Ажлын байр нэмэгдүүлэх</u>	1.320.4	140	729.7	1.320.4	736.5	48	590.7	188
2.	<u>ХАА-н салбарыг хөгжүүлэх</u>	1.152.5	237	205.5	832.3	69.6	13	946.9	250
3.	<u>Хувийн хэвшлийг хөгжүүлэх</u>	670.5	4	-	670.5	-	.	670.5	4
4.	<u>Орон сууцны төслийн зээл</u>	70.0	8	-	52.5	-	.	70.0	8
5.	<u>Бичил санхүүгийн зээл</u>	200.57	149	41.9	109.3	6.6	10	158.6	159
<u>Нийт дүн</u>		3.413.97	538	977.2	2.985.0	812.7	71	2.436.7	609

